



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

### Заавар батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Засгийн газрын 2022 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар”-ыг нэгдүгээр, “Албан журмын даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт тооцсон дэлгэрэнгүй жагсаалт”-ыг хоёрдугаар, “Сайн дурын даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт тооцсон дэлгэрэнгүй жагсаалт”-ыг гуравдугаар, “Нийгмийн даатгалын шимтгэлийн 2022 оны ... сарын буцаан олголтын нэгдсэн товчоо”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан зааврын хэрэгжилтийг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголттой холбоотой мэдээлэл өгч, сурталчлахыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт, зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтын санхүүжилтийг тогтоосон хугацаанд олгох, батлагдсан маягтаар мэдээ, тайлан гаргахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү), холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулж, даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг тогтоосон хугацаанд олгох нөхцөлийг бүрдүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Б.Батсүх)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЗОРИГТ








НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР


НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН  
ОЛГОХ, БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХАД  
БАРИМТЛАХ ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР


Баримт бичгийн дугаар: ЗВР-БХСГ- . . . -2022


Баталсан: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга  Д.ЗОРИГТ


Хянасан: Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга  Ц.ГАНЦЭЦЭГ

Санхүү бүртгэлийн газрын дарга  Б.ДАВААХҮҮ


Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн  С.ЛХАГВАДОРЖ

Санхүү бүртгэлийн газрын Ахлах мэргэжилтэн  Ц.ЭРДЭНЭТУЯА

Боловсруулсан: Санхүү бүртгэлийн газрын Нийгмийн даатгалын сангийн ахлах мэргэжилтэн  Б.НОМИНЖАРГАЛ

Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн  М.БЯМБАДУЛАМ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	





Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын БХСГ				

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл


Нэмэлт өөрчлөлт	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





## АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох аж ахуйн нэгж, байгууллага болон албан журмын даатгуулагчийг тодорхойлох
6. Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох сайн дураар даатгуулагчийг тодорхойлох
7. Даатгуулагчийн мэдээллийг бэлтгэх, нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, тайлагнах
8. Зааврын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох





Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн АЗС  
дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ,  
БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХАД БАРИМТЛАХ  
ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР**

**НЭГ. Зорилго**

1.1. Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 230 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам”-ын дагуу 1 000 000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос албан журмын болон сайн дурын даатгуулагч Монгол Улсын иргэн (цаашид “даатгуулагч” гэх)-ий өөрөө хариуцан төлсөн 2022 оны 5-12 дугаар сарыг дуусталх хугацааны тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл (цаашид “нийгмийн даатгалын шимтгэл” гэх)-ийн 50 хувийг сар бүр буцаан олгох (цаашид “буцаан олголт” гэх) ажлыг зохион байгуулахад энэхүү заавар (цаашид “заавар” гэх)-ыг мөрдөнө.

**ХОЁР. Хамрах хүрээ**

2.1. Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль (цаашид “хууль” гэх), “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам” (цаашид “журам” гэх)-д заасан 1 000 000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийг хамруулна.

**ГУРАВ. Хамаарах талууд**

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид “НДЕГ” гэх)-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү, бүртгэлийн газар, Мэдээллийн технологийн төв, Дотоод аудит, мониторингийн газар, Хяналт, шалгалтын газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, тасаг.

**ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч**

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Санхүү бүртгэлийн газар.



**ТАВ. Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох аж ахуйн нэгж,  
байгууллага болон албан журмын даатгуулагчийг тодорхойлох**

5.1. Дараах албан журмын даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг дараа сард нь буцаан олгоно:

5.1.1. Энэ зааврын 2.1-д заасан нөхцөлийг хангасан даатгуулагч;

5.1.2. Хоёр ба түүнээс дээш ажил олгогчоос олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэр нь 1 000 000 (нэг сая) ба түүнээс доош төгрөг бөгөөд уг орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч;

5.1.3. 2022 оны 5-12 дугаар сард нийгмийн даатгалын байгууллагад шинээр бүртгүүлж, тайлагнасан аж ахуйн нэгж, байгууллагын энэ зааврын 5.1.1, 5.1.2-т заасан даатгуулагч;

5.1.4. Тодорхой шалтгааны улмаас үйл ажиллагаа нь зогссон байсан боловч 2022 оны 5-12 дугаар сард үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагын энэ зааврын 5.1.1, 5.1.2-т заасан даатгуулагч.

5.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь 2022 оны 5-12 сард ажил олгогчийн болон даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хугацаанд сар бүр бүрэн төлсөн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчийн хариуцан төлсөн шимтгэлийн 50 хувийг буцаан олгоно.

5.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын 2022 оны 5-11 дүгээр сарын нийгмийн даатгалын шимтгэлийн буцаалтыг Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар баталсан төсвийн дагуу 2022 онд багтаан олгоно.

5.2.2. 2022 оны 12 дугаар сарын шимтгэлийг 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлсөн тохиолдолд 2023 оны 1 дүгээр сард даатгуулагчид шимтгэлийг буцаан олгоно.

5.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй тохиолдолд даатгуулагчийн төлсөн шимтгэлийг дараах байдлаар буцаан олгоно:

5.3.1. 2022 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй боловч 2022 оны 5-12 сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь бүрэн төлсөн тохиолдолд.

*Санамж<sup>1</sup>: 2022 оны 5-11 дүгээр сарын шимтгэлээ 11 дүгээр сарын 30-ны өдрийн, 2022 оны 12 дугаар сарын шимтгэлээ 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тус тус төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтод хамруулна.*

*Санамж<sup>2</sup>: Нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь төлөөгүйн улмаас тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан аваагүй боловч 2022 оны 5-12 сард даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийг санд бүрэн төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгоно. Энэ тохиолдолд энэ зааврын 5.2.1-д заасан хугацааг баримтлан нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгоно.*

*Жишээ 1: Аж ахуйн нэгж, байгууллага нь 2022 оны 5-7 сарын шимтгэлээ 8 дугаар сард төлсөн тохиолдолд дараа сард нь буюу 9 дүгээр сард 5-7 дугаар сарын шимтгэлийг даатгуулагчид нөхөн олгоно.*

5.4. Аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан



хугацаанд, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үнэн, зөв гаргаж, нийгмийн даатгалын байгууллагад цахим хэлбэрээр ирүүлсэн байна.

*Санамж<sup>4</sup>: Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн энэ зааврын 1.1-д заасан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан (З-НД-7, З-НД-8)-г хүлээн авч, баталгаажуулсан байна.*

### **Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох сайн дураар даатгуулагчийг тодорхойлох**

6.1. Дараах сайн дураар даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг буцаан олгоно:

6.1.1.1 000 000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч;

6.1.2. 2022 оны 5-12 дугаар сард сайн дураар даатгуулах гэрээ шинээр байгуулсан нийгмийн даатгалын шимтгэлээ гэрээнд заасан хугацаанд бүрэн төлсөн энэ зааврын 6.1.1, 6.1.3-т заасан даатгуулагч;

6.1.3.1 000 000 (нэг сая) ба түүнээс доош төгрөгийн орлогоос нийгмийн даатгалын шимтгэл (50 хувь)-ээ өөрөө хариуцан төлсөн сайн дураар даатгуулагч эх;

6.1.4. БНСУ дахь нийгмийн даатгалын албатай гэрээ байгуулсан энэ зааврын 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан даатгуулагч.

6.2. 2022 оны 12 дугаар сарын шимтгэлийг 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлсөн тохиолдолд 2023 оны 1 дүгээр сард даатгуулагчид шимтгэлийг буцаан олгоно.

6.3. Энэ зааврын 6.1.1-6.1.4-т заасан даатгуулагч 5-12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлээ урьдчилан төлсөн эсэхээс үл хамааран сар бүр нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгоно.

### **Долоо. Даатгуулагчийн мэдээллийг бэлтгэх, нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, тайлагнах**

7.1. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд хүлээн авч, баталгаажуулж, сайн дурын даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалтыг цаг хугацаанд нь хийж мэдээллийн санг үнэн зөв, бүрэн бүрдүүлнэ.

7.2. Мэдээллийн технологийн төв нь энэ зааврын 7.1-д заасан мэдээллийн санд үндэслэн нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт авах даатгуулагчийн судалгааг дараа сарын 10-ны өдрөөр, даатгуулагчийн гүйлгээний жагсаалтыг 20-ны өдрөөр тус тус тасалбар болгон бэлтгэж Санхүү бүртгэлийн газарт хүргүүлнэ.

7.3. Санхүү бүртгэлийн газар нь Сангийн яамны Төрийн сангийн газарт нээсэн түр данс руу энэ зааврын 7.2-т заасан гүйлгээний жагсаалтыг үндэслэн нийгмийн даатгалын холбогдох сангуудаас санхүүжилтийг шилжүүлнэ.



7.4.Журмын 3.2.3-т заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт авах даатгуулагчийн гүйлгээний жагсаалтыг сар бүрийн 25-ны өдрийн дотор Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

7.5.Санхүү бүртгэлийн газар нь нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтын холбогдох ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлагнана.

7.6.Санхүү бүртгэлийн газар нь нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтын тайланг сар бүрийн эцсийн өдрөөр тасалбар болгон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсэгт заасан хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Сангийн яаманд тус тус хүргүүлж, тооцоо нийлж, баталгаажуулна.

7.7.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь дансны мэдээлэл нь зөрүүтэй болон бүртгэлгүй даатгуулагчийн жагсаалтыг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчидтай холбогдож, данжуулах ажлыг зохион байгуулна.

### **Найм. Зааврын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох**

8.1.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Орлого, шимтгэлийн болон Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь даатгуулагчийн шимтгэлийн ногдуулалт, буцаан олголт авах даатгуулагчийг тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголтод сар бүр хяналт тавьж ажиллана.

8.2.Даатгуулагч хоёр буюу түүнээс дээш байгууллагад давхар ажилласны улмаас эсхүл тайлан хугацаа хоцроож ирүүлсэн тохиолдолд тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт хамрагдсан даатгуулагчийн илүү буюу үндэслэлгүй буцаан авсан нийгмийн даатгалын шимтгэлийг эргүүлэн төлөх арга хэмжээ авна.

8.3.Худал мэдээлсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлэн даатгуулагчийн тоо, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг бууруулсан эсхүл үндэслэлгүйгээр бууруулж нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олголт үндэслэлгүйгээр хамрагдсан нь нотлогдсон тохиолдолд буцаан олгосон нийгмийн даатгалын шимтгэлийг эргүүлэн төлүүлж, гэм буруутай хуулийн этгээд, даатгуулагч (иргэн)-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

